INNOVATION INVESTMENT

QPay

# 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот, 2024 он

# QPay

*Most accepted payment gateway*



INNOVATION INVESTMENT

# АГУУЛГА


## 01. КОМПАНИЙН ТУХАЙ

Компанийн тухай

Түүхэн замнал

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

Гүйцэтгэх удирдлагын баг

2023 оны Онцлох үйл явдал

## 02. БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Бэлэн бус төлбөр тооцооны зах зээлийн тухай

Санхүүгийн онцлох тоон үзүүлэлтүүд

Мэдээлэл технологийн үйл ажиллагаа

Эрсдэлийн удирдлага

Нийгмийн хариуцлага

## 03. САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын дүгнэлт

Санхүү байдлын тайлан

Орлого үр дүнгийн тайлан

Өмчийн өөрчлөлтийн тайлан

Мөнгөн гүйлгээний тайлан

## 04. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Хувьцаа эзэмшигчдийн хурал

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал, үйл ажиллагаа

Хувьцааны мэдээлэл

Ногдол ашгийн бодлогын хэрэгжилт

# 01. КОМПАНИЙН ТУХАЙ

*Компанийн тухай*

*Түүхэн замнал*

*Гүйцэтгэх удирдлагын баг*

*Гүйцэтгэх захирлын мэндчилгээ*

*2023 оны Онцлох үйл явдал*

# 01. КОМПАНИЙН ТУХАЙ

## АЛСЫН ХАРАА

Хүний амьдралыг таатай болгох дижитал шийдэлд хөрөнгө оруулалт хийж, тогтвортой ирээдүйг бүтээх үйлсэд хувь нэмрээ оруулна.

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Технологид суурилсан инновацлаг шийдэлд зохистой хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлж, шинэ үеийн нийгэм, хүмүүсийн амьдралын хэв маягт нийцсэн дижитал дэд бүтцийг бүрдүүлэх үйлсийг манлайлна.

## ҮНЭТ ЗҮЙЛС

- Тэмүүлэл
- Багийн ажиллагаа
- Хүчтэй түншлэл, харилцаа
- Хариуцлага
- Хэрэгцээг ойлгодог
- Ухаалаг
- Тэнцвэртэй байдал
- Тогтвортой хөгжил

## КОМПАНИ БҮТЭЦ

INNOVATION INVESTMENT

Инновэйшн Инвестмент ХХК нь 2017 оноос эхлэн Технологийн шинэлэг шийдэлд хөрөнгө оруулалт хийх зорилготойгоор анх үүсгэн байгуулагдсан.

Одоогоор QPAY үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, удирдах “КKTT” ХХК, Мерчантуудад чиглэсэн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах “Дижитал мерчант сервисэс” ХХК гэх 2 охин компанитайгаар үйл ажиллагаа явуулж байна.

## ОХИН КОМПАНИУД

KKTT

“KKTT” ХХК нь программ хангамж, мэдээ боловсруулах, техник хангамжийн үйл ажиллагааны чиглэлээр 2010 оны 07 сарын 28 ны өдөр үүсгэн байгуулагдсан.

DMS

“Дижитал Мерчант Сервисэс” ХХК нь 2019 оны 07 сарын 05 ны өдөр үүсгэн байгуулсан бөгөөд тус компани нь Мерчант байгууллагуудад чиглэсэн үйлчилгээ нэвтрүүлэн ажиллаж байна.

# 02. ТҮҮХЭН ЗАМНАЛ

Инновэйшн инвесмент ХХК нь 2017 оноос хойш технологийн хурдацтай хөгжилд тулгуурлан иргэдийн өдөр тутмын амьдралын хэв маягийг хялбаршуулж, бэлэн бус төлбөр тооцооны QPay QR төлбөрийн экосистемийн үйлчилгээг нийт үйлчлүүлэгч, харилцагч байгууллагууддаа үзүүлэн мэдээлэл технологийн салбарт шинэчлэг бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэн ажиллаж байна.

QPay

## 2016

Хаан банканд анхны нэвтрүүлэлт хийгдэхээр тохиролцож QR код уншуулан гүйлгээ хийх анхны хөгжүүлэлт хийгдэв.

INNOVATION INVESTMENT

## 2017

Анхны хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэхээр группийн толгой компанийг буюу “Инновэйшн Инвестмент” ХХК-ийг үүсгэн байгуулав.

## 2018

Төлбөр хүлээн авагч мерчант байгууллага болон Хэрэглэгчийн систем нийлүүлэгчид зориулсан QR нэхэмжлэх үүсгэх боломжтой API-ийн version 2.0 хувилбарыг нэвтрүүлэв.

## 2019

Pos/кассын систем хөгжүүлэлт буюу Хэрэглэгчийн систем нийлүүлэгч компаниудад зориулан шинэчилсэн шинэ POS API хөгжүүлж нэвтрүүлэв.

UnionPay

## 2020

QR нэхэмжлэх үүсгэх мерчантын шинэ API version 2.0 хувилбарыг нэвтрүүлэв

Олон улсын картын Unionpay үйлчилгээтэй хамтын ажиллагааг эхлүүлж картын системд холбогдов

## 2022

Дэлхийн 64 улсад нэвтэрсэн БНХАУ-ын хамгийн өргөн хэрэглээтэй цахим төлбөрийн систем болох олон улсын WechatPay үйлчилгээтэй экосистемийн гэрээ байгуулж Монгол улсдаа анхлан нэвтрүүлэв.

IPO Pay

## 2023

Технологийн салбарын анхны IPO-г амжилттай хийлээ



## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид ээ,

Эрхэм хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагч, хамтран ажилладаг түнш байгууллагууд, хүндэт хэрэглэгч та бүхний амгаланг эрэн мэндчилье.

Та бүхэнд Инновэйшн Инвестмент ХХК-ийн 2023 оны санхүү, үйл ажиллагааны үр дүнгийн талаар тайлагнан мэндчилж байна.

QR болон дижитал төлбөр тооцооны салбарт гарсан гайхалтай амжилтуудаас гадна бид Монгол улсад анх удаа мэдээллийн технологийн салбарт Монголын хөрөнгийн бирж дээр олон нийтэд хувьцаагаа санал болгож амжилттай дууссан түүхэн чухал үйл явдлыг онцолж байгаадаа бахархаж байна. Энэхүү чухал явдал нь манай компанийн хувьд салбартаа түүчээ болсон байр суурийг тодотгоод зогсохгүй манай улсын технологийн салбарыг бүхэлд нь ахиулсан томоохон алхам болж байна.

Жилийн туршид динамик, байнга хувьсан өөрчлөгдөж буй зах зээлийн орчинд манай компани стратегийн зорилгодоо тууштай, дасан зохицох чадвараа харуулсан. Санхүүгийн хувьд бид дижитал төлбөрийн шинэлэг шийдлүүд болон зах зээлийг тэлэх стратегийн санаачилгуудыг харилцагч, хамтран ажиллагч түншүүд, ажилтнуудтайгаа хамтран өргөнөөр нэвтрүүлснээрээ хүчтэй өсөлтийг мэдэрсэн. Энэхүү өсөлт нь хувьцаа эзэмшигчдэдээ үнэ цэнийг хүргэх гэсэн бидний зүтгэлийг онцолж байна.

Үйл ажиллагааныхаа хувьд бид инноваци, үйлчлүүлэгчид төвлөрсөн байдал, үйл ажиллагааны шилдэг байдлыг чухалчилсан жил боллоо. Бид 2023 онд технологийн тасралтгүй хөгжүүлэлтийг хийж эрхэм үйлчлүүлэгчдэдээ дижитал гүйлгээний хэрэглээ, аюулгүй байдал, үр ашгийг дээшлүүлсэн шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх боломжийг бидэнд олголоо.

Түүнчлэн компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд бид дижитал төлбөр тооцооны шийдлээр дамжуулан Төрийн үйлчилгээний цаасны хэрэглээ, хэрэглэгчдийн цаг хугацаа, үйлчилгээ авах замын зардлыг багасгаж Монгол улс гэлтгүй дэлхийн хэмжээнд тулгарч буй нүүрстөрөгчийн хийн асуудалд үнэтэй хувь нэмэр оруулан ажиллаж байна.

Цаашид бид Инновэйшн Инвестмент компанийн ирээдүйг өөдрөгөөр харж байгаа бөгөөд Дижитал төлбөрийн салбар цаашид өргөжин тэлэх хандлагатай байгаа нь бид шинээр гарч ирж буй боломжуудыг ашиглах, хувьсан өөрчлөгдөж буй хэрэглэгчдийн хэрэгцээг хангахад бэлэн байна.

Инновэйшн Инвестмент ХХК-д итгэл найдвар тавьж, тууштай дэмжлэг үзүүлсэн эрхэм хувьцаа эзэмшигчид та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлье. Мөн шаргуу хөдөлмөр, бүтээлч байдал, хичээл зүтгэлээрээ энэхүү амжилтыг авчирсан хамт олондоо чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлж байна.

*Хүндэтгэсэн:* *Г. Эмөнх* *Гомбодоржийн Эрдэнэмөнх*

# 04. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ



**Г . ЭРДЭНЭМӨНХ**
*CEO*

*2022 оноос "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаа.*



**Б . ЭНХБОЛД**
*CFO*

*2021 оноос "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Санхүү эрхэлсэн захиралаар ажиллаж байгаа.*



**Д . ЖАНЧИВ**
*CTO*

*2021 оноос "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Технологи хариуцсан захиралаар ажиллаж байгаа.*



**О . ХОНГОР**
*CBO*

*2022 оноос "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Бизнес хөгжил хариуцсан захиралаар ажиллаж байгаа.*



**Ц . ГОМБОДОРЖ**
*CISO*

*2022 оноос "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Мэдээллийн аюулгүй байдал хариуцсанзахиралаар ажиллаж байгаа.*



**Я . ОЮУНХАНД**
*ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ*

*2019 оноос "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Ерөнхий нягтлан бодогч*



**С . ГҮРЖАВ**
*"ДИЖИТАЛ МЕРЧАНТ СЕРВИСЭС" ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ*

*2019 оноос "Дижитал Мерчант Сервисэс" ХХК-ийн Гүйцэтгэх захиралаар ажиллаж байгаа.*

# 05. 2023 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



## ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫН АНХНЫ IPO-Г АМЖИЛТТАЙ ХИЙЛЭЭ

*Инновэйшн Инвестмент ХК нь 2023 оны 12 сарын 4 өдөр олон нийтэд компанийн 20 хувь буюу 36,977,618 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 225 төгрөгөөр санал болголоо.*

*Анхдагч арилжаа амжилттай явагдаж 8.3 тэрбум төгрөгийг олон нийтээс татан төвлөрүүлж, 1,155 хувьцаа эзэмшигчтэй нээлттэй хувьцаат компани боллоо.*



## БҮХ БАНКНУУДЫГ QPAY ҮЙЛЧИЛГЭЭНД НЭГТГЭВ

*Голомт банкны SocialPay үйлчилгээг QPay системд холбосноор Монгол улсын бүх арилжааны банкнуудтай хамтран ажилладаг боллоо.*



## МОНГОЛ БАНКНААС БАТАЛСАН QR СТАНДАРТЫГ ХАНГАЛАА

*Монгол банкнаас QR стандарт шинэчлэгдсэнтэй холбоотойгоор системийн холболт хийгдсэн Банк, Хэрэглэгчийн систем нийлүүлэгч, Вендор болон Мерчант байгууллагуудын QR кодыг стандартын дагуу бүрэн шинэчилж нэвтрүүллээ.*




## БНХАУ-ЫН WECHATPAY АППЛИКЭЙШНААС МОНГОЛДОО ТӨЛБӨР ХҮЛЭЭН АВДАГ БОЛЛОО.

*Дэлхийн 64 улсад нэвтэрсэн БНХАУ-ын хамгийн том цахим төлбөрийн систем болох WeChatPay үйлчилгээтэй хамтран ажиллах экосистемийн гэрээг байгуулж системийн түвшинд холболт хийлээ. Монгол төгрөг нь WeChatPay системийг дэмждэг 25 дахь валют болж дотоодын бизнес эрхлэгч нарт БНХАУ-ын иргэдээс Монгол дахь төгрөгийн дансандаа төлбөрөө хормын дотор хүлээн авах боломжтой боллоо.*



## SFF 2023 EXPO-Д АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО

*Сингапур улсад жил бүр зохион байгуулагддаг дэлхийн хамгийн том финтекийн экспо болох Singapore Fintech Festival үзэсгэлэн яармагт QR бэлэн бус төлбөрийн системийн үйлчилгээг танилцуулж амжилттай оролцлоо*




## QPAY – ZEROPAY (БНСУ) ХАМТЫН АЖИЛЛАГААГ ЭХЛҮҮЛЛЭЭ

*БНСУ-ын хамгийн том QR бэлэн бус төлбөрийн систем болох Zeropay үйлчилгээтэй хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа. Энэхүү хамтын ажиллагааны үр дүнд Солонгос улсын иргэд ZeroPay – ээр QPay-ийн 280,000 гаруй мянган худалдаа, үйлчилгээний байгууллагад төлбөр төлөх, Харин QPay –ийн хэрэглэгчид Солонгос улсын 1,1 сая гаруй худалдаа, үйлчилгээний байгууллагад төлбөр төлөх боломжийг нээлээ.*




## QPAY ХЭТЭВЧ ТОКЕН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СИСТЕМ НЭВТРҮҮЛЛЭЭ

*Монгол банкнаас Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн «Төлбөрийн системийн шинэчлэл» төслийн хүрээнд Мобайл төлбөр тооцооны токен систем буюу Токен үйлчилгээний систем (TSP)-ийг амжилттай нэвтрүүлээд байна.*



## QPAY СИСТЕМИЙН ТОГТВОРТОЙ АЖИЛЛАГАА НЭМЭГДЛЭЭ

*QPay үйлчилгээний бусад системээс хамаарсан доголдлыг бууруулах, системийн 53 нэмэлт өргөтгөл, шинэчлэлт хийгдэж QPay системийн байнгын тогтвортой, найдвартай байдлыг бүрэн хангаж ажиллалаа.*




## QPAY – SENDMN ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ ҮЗЭГЛЭЛЭЭ

*БНСУ, ОХУ, БНТУ, БНСВУлс зэрэг улсын иргэд, жуулчдад Монгол улсад QPAY үйлчилгээний QR кодыг уншуулан хил дамнасан гүйлгээ хийх боломжийг нэвтрүүлэхээр мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгч SENDMN-тэй хамтран ажиллах санамж бичиг байгууллаа.*




## UNIONPAY ОЛОН УЛСЫН КАРТЫН ГҮЙЛГЭЭГ ШИНЭЧИЛСЭН СТАНДАРТЫН ДАГУУ АМЖИЛТТАЙ НЭВТРҮҮЛЛЭЭ

*QPAY WALLET аппликейшн болон Банкны аппликэйшнд өөрийн ЮнионПэй картаа холбон Монголд төдийгүй Дэлхийн 30 гаруй улсын 20 гаруй сая, худалдаа үйлчилгээний байгууллагын QR төлбөр тооцоог шимтгэлгүйгээр хийх боломжийг олгож байна.*



## ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН НУУЦЛАЛ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ БҮРЭН ХАНГАЖ АЖИЛЛАЛАА.

*Төлбөрийн системийн нууцлал, аюулгүй байдлыг хангах зорилгоор сүлжээнүүдийг тусгаарлах (NETWORK SEGMENTATION), сүлжээний IPS функцтэй FORTIGATE 100F төхөөрөмжийг суурилуулж байгууллагуудтай үүсгэсэн VPN сүлжээг тасалдал багатайгаар шилжүүлэх, сүлжээг тусгаарлах ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэлээ. Мөн картын болон банк, мерчантууд ашиглах API, вэб сервисүүдийг гадны халдлагаас хамгаалах зорилгоор Вэб файрвол (WAF) төхөөрөмжийг сүлжээний гарц дээр байршуулснаар API түвшинд ирж байгаа халдлагыг бүртгэх, хязгаарлаж эхэллээ.*

# 02. БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

*Бэлэн бус төлбөр тооцооны зах зээлийн тухай*

*Санхүүгийн онцлох тоон үзүүлэлтүүд*

*Мэдээлэл технологийн үйл ажиллагаа*

*Эрсдэлийн удирдлага*

*Нийгмийн хариуцлага*

# 01. БЭЛЭН БУС ТӨЛБӨР ТООЦООНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ

Монгол Улсын төлбөрийн системийн эрх зүйн орчныг шинэчлэх ажлын хүрээнд "Үндэсний төлбөрийн системийн тухай хууль" 2017 оны 5 дугаар сарын-31нд батлагдаж, 2018 оны 01 дүгээр сарын --01нээс мөрдөгдөж эхэлсэн. Энэ хууль нь Монгол Улсын үндэсний төлбөрийн системийг удирдах, зохион байгуулах, зохицуулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахаас гадна Үндэсний төлбөрийн системд банкнаас бусад этгээд оролцох боломжийг нээж өгсөн байдаг.

Төлбөр тооцооны системийн үндсэн зорилго нь банк, санхүүгийн салбарт хийгдэж буй төлбөр тооцоог тасралтгүй, найдвартай, шуурхай гүйцэтгэх замаар нийт эдийн засаг дах мөнгөний эргэлтийг хурдасгах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах явдал юм. Иймд төлбөрийн систем нь санхүүгийн системийн дэд бүтцийн чухал хэсэг төдийгүй мөнгөний бодлогыг дамжуулах гол суваг болж үйлчилдэг. Сүүлийн жилүүдэд өндөр түвшний технологи нэвтрэхтэй зэрэгцэн зах зээлийн хөгжлийн хандлага, эрэлт шаардлагад нийцсэн бэлэн бус төлбөрийн шинэ дэвшилтэт хэрэгслүүд хурдацтайгаар бий болж, төлбөр тооцоог түргэн шуурхай, үр ашигтай гүйцэтгэх боломж бүхий шинэ системүүдийг нэвтрүүлэхэд хүргэсэн. Эдгээр системийн үр ашигтай, хэвийн ажиллагаа нь байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн, бизнес эрхлэгчдэд санхүүгийн үүргээ биелүүлэх, мөнгөн хөрөнгөө аюулгүй, цаг тухайд нь шилжүүлэх боломжийг олгож байна.

## БЭЛЭН БУС ГҮЙЛГЭЭНИЙ ТОО, ҮНИЙН ДҮН



2017 онд 321 сая ширхэг гүйлгээ бэлэн бусаар хийгдэж байсан бол 2023 оны эхний 3 улирлын байдлаар нийт бэлэн бус гүйлгээний тоо 1.3 их наяд ширхэгт хүрч 4.1 дахин өссөн бол үнийн дүнгийн хувьд 76 их наяд төгрөгөөс 325 их наяд төгрөгт хүрч 4.3 дахинаар өссөн байна. Гэсэн хэдий ч иргэд АТМ-ээс бэлэн мөнгө гарган өдөр тутмын хэрэглээ, худалдан авалт, үйлчилгээндээ ашигласан хэвээр байгаа юм. АТМ-ээс бэлнээр гаргасан мөнгийг иргэд хэд хэдэн удаа үйлчилгээнд ашиглан дамжуулсны эцэст буцаж банканд ирдэг. Бэлэн мөнгөний хэрэглээг улам бууруулбал бэлэн бус гүйлгээний тоо нэлээд хувиар цаашид өсөх бололцоо их байна.

Хэрэглэгчдийн хувьд цаашид бэлэн бусаар төлөх дадал улам нэмэгдэж байгаа бөгөөд байгууллагууд түүнд нийцсэн шинэ үйлчилгээнүүдийг ихээр бий болгож зах зээл нэлээд тэлэх төлөвтэй байна.

Гэсэн хэдий ч Монгол улсын нийт бэлэн бус төлбөрийн зах зээлд QPAY үйлчилгээний эзлэх хувь хэмжээ харьцангуй бага байгаа нь цаашид өсөх боломж нэлээдгүй байгааг харуулж байна.




## ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ

QPAY үйлчилгээгээр хийгдэж буй гүйлгээнүүд нь 2022 оны эцсээр энэхүү зах зээлийн 4.1 хувийг эзэлж байсан бол 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 6.5 хувьд хүрч байнгын өсөлтийг үзүүлж байна.

## МЕРЧАНТЫН ӨСӨЛТ

QPay системийн холболт хийсэн байгууллагын тоо 2022 онд 7,300 гаруй байсан ба 2023 онд -40,000 аар нэмэгдүүлж нийт 48,000 гаруй системийн холболттой болон стикер QR мерчантын хувьд 260,000 мерчанттай боллоо.



# 02. САНХҮҮГИЙН ОНЦЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## ТӨСВИЙН БИЕЛЭЛТ

2023 онд 5.7 их наяд төгрөгийн 118.1 сая ширхэг гүйлгээ хийхээр төсөвлөж байсан бол 5.9 их наяд төгрөгийн 121.4 сая ширхэг гүйлгээг QPay-ээр дамжуулснаар төсвийн биелэлт 103 хувьтай гарсан.

### ГҮЙЛГЭЭНИЙ ТОО /САЯ.ШИРХЭГ/




### ГҮЙЛГЭЭНИЙ ҮНИЙН ДҮН /ИХНАЯД ТӨГРӨГ/




## ГҮЙЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ БА ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2023 он бол гүйлгээний тоо, гүйлгээний үнийн болон борлуулалт зэрэг бүхий л статистик үзүүлэлтийн хувьд өндөр өсөлттэй жил байлаа. Гүйлгээний дүн, гүйлгээний тоо, зэрэг статистик үзүүлэлтүүдийг доорх байдлаар тодруулан бэлтгэлээ.

Нэгж гүйлгээний дундаж үнийн дүн
+ 4.2%
2022 ▲
48,000 ₮
18%

Сарын дундаж гүйлгээний тоо
10.1 САЯ ШИРХЭГ

Өдрийн дундаж гүйлгээний тоо
332.1 МЯНГАН ШИРХЭГ

Сарын дундаж гүйлгээний үнийн дүн
490.1 ТЭРБУМ ТГРӨГ

Өдрийн дундаж гүйлгээний үнийн дүн
16.1 ТЭРБУМ ТГРӨГ

# 02. САНХҮҮГИЙН ОНЦЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## БОРЛУУЛАЛТ БА АШГИЙН ХАРЬЦАА




“Нийт ашиг” болон “цэвэр ашгийн” түвшин 2023 оны хувьд %54 ба %43 байгаа нь үндсэн үйл ажиллагааны ашгийн түвшин маш сайн байгааг харуулж байна. 2023-2021 оны хооронд Борлуулалтын орлого өмнөх онтой харьцуулахад 109, нийт ашиг 38, цэвэр ашиг 64 хувийн өсөлтийг тус тус үзүүлсэн нь өртөг болон үйл ажиллагааны зардлын хяналт сайн буюу ашгийн түвшнийг тогтмол өндөрт барьж чадлаа.

## НИЙТ ХӨРӨНГӨ /САЯ.ТӨГРӨГ/




## ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН /САЯ.ТӨГРӨГ/




2023-2019 оны хооронд нийт хөрөнгө болон эздийн өмч тогтмол өсч /CAGR/ буюу жилийн нийлмэл өсөлтийн дундаж түвшин %52 байна.

2023 онд МХБ дээр IPO хийж олон нийтээс 8.3 тэрбум төгрөг татан төвлөрүүлсний үр дүнд нийт хөрөнгийн хэмжээ 18.7 тэрбум төгрөгт хүрч өссөн бөгөөд энэ нь төсөвлөсөн дүнгийн 176 хувьтай тэнцүү хэмжээтэй байна.

# 02. САНХҮҮГИЙН ОНЦЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ (ROE)




2023 онд өөрийн хөрөнгийн өгөөж %33 байгаа нь салбарын болон Монголын хөрөнгийн бирж дээрх хувьцаат компаниудын дундаж жишиг үзүүлэлтээс илүү байгаа ба хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын хөрөнгийн үнэ цэнийг хамгаалан амжилттай ажиллаж байна. 2023 оны эцэст IPO хийж компанийн эздийн өмчийн дүн 8.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн учир өөрийн хөрөнгийн өгөөж өмнөх жилүүдийн дунджаас буурсан байна.

2023 онд группийн хэмжээнд ОАТ-т 533,860 мянган төгрөг, НӨАТ-т 962,539 мянган төгрөг, Цалин хөлстэй холбоотой татварт 150,720 мянган төгрөг, нийгмийн даатгалын байгууллагад 340,015 мянган төгрөгийн шимтгэл, жилдээ нийт 1,987,134 мянган төгрөгийн татвар, шимтгэлийг төлсөн байна.

# 03. МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

QPay бизнест шаардлагатай программ хангамжийн судалгаа, хөгжүүлэлт, тогтвортой үйл ажиллагааг тасралтгүй хангах чиг үүргийн дагуу харилцагч болон мерчант, бусад нэгжүүдийн захиалгаар программ хангамжийн шаардлага боловсруулах, систем анализ хийх, хөгжүүлэлт хийх, чанарын хяналт хийх, нэвтрүүлэх гэх мэт төрөл бүрийн шаардлага бүхий мэдээллийн систем, программ хангамжуудыг амжилттай хөгжүүлэн нэвтрүүлж, засвар үйлчилгээ, хэвийн ажиллагааг хариуцан ажиллаж байна.

QPay гүйлгээний бусад системээс хамаарсан доголдлыг бууруулах, системийн нэмэлт өргөтгөл шинэчлэл хийх ажлын хүрээнд 53 шинэчлэлт хийгдэж QPay системийн байнгын тогтвортой, найдвартай байдлыг бүрэн хангаж ажиллалаа.

Бид систем хөгжүүлэлтдээ Agile аргачлалын Scrum загварыг ашиглахаар зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд хөгжүүлэлтийн цикл (Sprint) үүсгэн ажиллаж байна.

**Үе шат тус бүрд дараах үйл ажиллагаануудыг тогтмол хийж байна.**

- Шаардлага, цар хүрээг нарийвчлан тодорхойлох

  Энэ үе шатанд захиалагч болон системийн эцсийн хэрэглэгчдийн хэрэгцээ, системээс хүлээж буй үр дүнг нарийвчлан тогтоож, үүнд үндэслэн хэрэгцээ шаардлага, User-story -уудыг нарийвчлан тодорхойлно.

- Архитектур, дизайныг боловсруулах

  Энэ үе шатанд өмнө хийсэн судалгаа, цар хүрээний дагуу системийн архитект, дэлгэцийн загвар (mock-up) болон prototype бэлтгэнэ.

- Систем хөгжүүлэлт

  Боловсруулсан архитектур, дизайны дагуу хөгжүүлэгчид ажиллаж кодчиллын стандарт, чанарын удирдлагын төлөвлөгөөний дагуу систем хөгжүүлэлт хийнэ.

- Чанарын хяналт, тест

  Бэлэн болсон модулиудын хоорондын уялдаа холбоо, хэвийн ажиллагаа, захиалагчийн хэрэгцээ шаардлагад нийцэж буй эсэхийг туршиж, шаардлагатай нэмэлт, өөрчлөлт хийнэ.

- Суурилуулалт, нэвтрүүлэлт

  Туршилтын үр дүнд гарсан алдааг засаж, нэмэлт өөрчлөлтүүдийг тусган, дараагийн туршилтад шилжүүлэн системийн шинэ хувилбарыг серверт байршуулж, үйл ажиллагаанд оруулж хэвийн үйл ажиллагааг хანган ажиллаж байна.

# 03. МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА




Төлбөрийн картын гүйлгээний аюулгүй байдлын стандарт болох PCI DSS стандартын баталгаажуулалтыг магадлах аудитын ажлыг олон улсын хөндлөнгийн аудитын байгууллагаар хийлгэж холбогдох стандарт шаардлагуудыг бүрэн биелүүллээ.

QPay үйлчилгээний эмзэг байдлын түвшинг БНЭУ-ын SISA байгууллагатай хамтран External Vulnerability Assessment улирал тутам хийлгэж байна.

Төлбөрийн системийн нууцлал, аюулгүй байдлыг хангах зорилгоор сүлжээнүүдийг тусгаарлах (Network segmentation), сүлжээний IPS функцтэй FortiGate 100F төхөөрөмжийг суурилуулсан.

Сүлжээний үндсэн төхөөрөмжийг сольж байгаатай холбогдуулан байгууллагуудтай үүсгэсэн VPN сүлжээг тасалдал багатайгаар шилжүүлэх, сүлжээг тусгаарлах ажлуудыг ажилттай хийж гүйцэтгэсэн. Мөн картын болон банк, мерчантууд ашиглах API, вэб сервисүүдийг гадны халдлагаас хамгаалах зорилгоор Вэб файрвол (WAF) төхөөрөмжийг сүлжээний гарц дээр байршуулсан. Ингэснээр API түвшинд ирж байгаа халдлагыг бүртгэх, хязгаарлах боломж бүрдсэн.

# 04. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд зохицуулагч байгууллагаас гаргасан тогтоол, дүрэм, эрх зүйн актад нийцүүлэн 2023 онд Мэдээллийн аюулгүй байдлын бодлого, холбогдох журам заавруул, Эрсдэлийн удирдлагын бодлого журмыг шинэчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Эрсдэлийн удирдлагын үр дүнтэй тогтолцоог хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтлан ажиллаж байна.

- Үнэт зүйлийг бий болгох, хамгаалах: Компанийн зорилго, зорилтод хүрэх, гүйцэтгэлээ сайжруулах үйл ажиллагааны чухал хэсэг байна.
- Шийдвэр гаргалтын салшгүй хэсэг байх: Компанийн удирдлагын зүгээс аргахэмжээгэрэмбэлэнтөлөвлөх,сонголтхийхэддэмжлэгүзүүлдэгбайна.
- Нөхцөл байдалдаа тохирсон байх: Авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь эрсдэлийн мөн чанар, эх үүсвэрт тохирсон байна.
- Ил тод, оролцоог хангасан байх: Компанийн бүх түвшний шийдвэр гаргагчдын оролцоог хангасан мэдээллийн урсгал нээлттэй байна.
- Байнга сайжирдаг байх: Эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр дүнтэй байдлыг тогтмол хянаж, тасралтгүй сайжруулдаг байна.

# 05. НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

## БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО




“Инновэйшн Инвестмент” ХХК нь бүх шатны үйл ажиллагаандаа Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Тогтвортой Хөгжлийн зорилтуудыг 2020 оноос хойш хэрэгжүүлэн ажиллаж байна. Байгууллагын тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд “Инновэйшн Инвестмент” ХХК нь өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан байгаль орчин, нийгэм эдийн засагт зэрэг нөлөөлөл бий болгох, дотоод үйл ажиллагаагаа байгаль, нийгэмд ээлтэй болгохоор зорин ажиллаж байна.

“Инновэйшн Инвестмент” ХХК нь өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан байгаль орчин, нийгэм эдийн засагт эерэг нөлөөлөл бий болгох, дотоод үйл ажиллагаагаа байгаль, нийгэмд ээлтэй болгохоор зорин ажиллаж байна. “Инновэйшн Инвестмент” ХХК-ийн байгаль орчин, нийгэм, засаглалын тогтвортой хөгжлийн бодлогын чиглэл нь тогтвортой бизнесийн үйл ажиллагааг явуулах, нийгэм, байгаль орчны асуудлуудад анхаарал хандуулах, тогтвортой, сэтгэл ханамжтай ажлын байрыг бий болгох юм.

## БАЙГАЛЬ, ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ТУХАЙ

“Инновэйшн Инвестмент” ХХК-аас үзүүлдэг Qpay үйлчилгээ нь цахим төлбөрийн хэрэгслийг хялбар болгож, QR төлбөр тооцоог хүн бүрд нээлттэй болгон ойртуулсан билээ. Энэхүү үйлчилгээний

нөлөөллөөр Хэрэглэгчид банкны урт дараалалд зогсолгүй цахим QR гүйлгээгээр төлбөрөө гүйцэтгэх болсон. Хэрэглэгчийн тоо нэмэгдэх хэрээр цаг хугацаа, шаардлагагүй зардал болон хог хаягдал буурж, бүх талуудын сэтгэл ханамж өсөж байна.

Банкны 1 гүйлгээний ард 1 ширхэг А4 цаас ашиглагддаг гэж үзвэл Qpay үйлчилгээ нь 2023 оны турш зөвхөн төрийн үйлчилгээний хувьд 2,268,458 ширхэг цаас хэмнэснээр 272 мод, 837 тонн ус, 39м3 нүүрс хүчлийн хийн ялгаруулалтыг тус тус хэмнэсэн байна.

“Инновэйшн Инвестмент” ХХК нь Qpay үйлчилгээг Монгол Улсын зах зээлд нэвтрүүлснээс хойш доорх хэмнэлтүүдийг бий болгож цахим төлбөр тооцооны шинэ соёлыг нэвтрүүлжээ.

### НИЙТ QPAY ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ДАМЖУУЛЖ БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛСЭН ЭЕРЭГ НӨЛӨӨ



**121,390,614**
**ЦААС**



**14,567**
**МОД**



**44,668**
**ТОНН УС**



**2,097m3 $CO^2$**
**ЯЛГАРУУЛАЛТ**

### НИЙТ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ДАМЖУУЛЖ БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛСЭН ЭЕРЭГ НӨЛӨӨ

**2,268,458**
**ЦААС**

**272**
**МОД**

**837**
**ТОНН УС**

**39m3 $CO^2$**
**ЯЛГАРУУЛАЛТ**

## НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ НӨЛӨӨЛЛИЙН ТУХАЙ

“Инновэйшн Инвестмент” ХХК нь нийгэм, эдийн засгийн тогтвортой байдалд дараах хувь нэмрийг оруулжээ.

• Амьдралын хэв маягийг хялбар, аюулгүй болгох: Qpay үйлчилгээ нь олон улсын төлбөрийн системүүдтэй холболт хийгдсэнээр гадаад улсад суралцагч оюутан залуус болон аялагч, бизнес эрхлэгч Монгол Улсын иргэд бэлэн мөнгөөр гүйлгээ хийх шаардлагагүй болж бэлэн мөнгөтэй болон мөнгөн гуйвуулгатай холбоотой гарч буй гэмт хэргийн тоог бууруулах боломжийг бүрдүүлсэн.

• Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, цахимжуулах хөтөлбөрийг дэмжих: Төрөөс үзүүлж буй бүхий л үйлчилгээний төлбөрийг үйлчилгээг ашиглан шимтгэлгүйгээр, хурдан, хялбараар гүйцэтгэх боломжтой болсон нь иргэд болон төрийн албаны цагийг хэмнэж, ачааллыг бууруулсан шийдэл болсон.

• Жижиг, дунд, бичил бизнес эрхлэгчдийг дэмжих: Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор стикер QR кодыг ашгийн төлөө худалдалгүй, үнэгүй хэвлэн тарааж өгсөн. Мөн Мерчантууд нь бүртгэлийн хураамжгүйгээр Qpay Мерчант аппликэйшн эсвэл вэб хуудаст хандан бүртгүүлэн орлогын мэдээлэл, гүйлгээний түүхээ үзэх боломжтой байна.

• Нийгмийн хариуцлагын хүрээнд УИХ-ын сонгуулийн нэр дэвшигчийн хандивын эх үүсвэрийг нээлттэй тодорхойлох боломжтой тусгай QR гүйлгээг нэвтрүүлсэн.

## БАЙГУУЛЛАГЫН ЗАСАГЛАЛ

“Инновэйшн Инвестмент” ХХК нь байгууллагын засаглалын тогтвортой байдалд дараах үзүүлэлтүүдийг баримталж байна.

• “Инновэйшн Инвестмент” ХХК нь группийн хэмжээнд ажилтнууд жендерийн эрх тэгш харьцаатай байж бие биеийнхээ эрх, үүрэг, харилцааг хүндлэн ажиллах соёлтой байхыг дэмждэг. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үед хүйсийн харьцаа 50:50 байна.

• “Инновэйшн Инвестмент” ХХК нь засаглалын хүрээнд удирдлагын бүтэц, зохион байгуулалт, бодлого, тогтолцоонуудыг оновчтой, зөв зохистой, болгон бүрдүүлж хөгжүүлэхэд анхаарч ажиллаж байгаа бөгөөд нэн тэргүүнд үнэн, зөв мэдээллээр удирдлагыг цаг алдалгүй хангаж, шийдвэр гаргалтыг бодитой, оновчтой, шуурхай, зөв зохистой болгох механизмыг бүрдүүлж, ил тод, нээлттэй, өндөр хариуцлагатай гүйцэтгэлийн удирдлага, хяналтын тогтолцоог бий болгон бэхжүүлэх чиглэлээр сайжруулалт хийн ажиллаж байна.

• “Инновэйшн Инвестмент” ХХК нь цалин, урамшууллын тогтвортой байдлыг хангахын тулд ажилтны гүйцэтгэлийг үнэлэх, урамшуулал олгох журмыг бэлтгэн нэвтрүүлэхээр ажиллаж байна.

• Мэдээллийн аюулгүй байдлын чанарыг сайжруулж дотоод үйл ажиллагаандаа ISO:27001 стандартыг нэвтрүүлсэн бөгөөд харилцагчийн мэдээллийг хамгаалах найдвартай байдлыг хангах зорилгоор олон улсын төлбөр тооцооны хэрэгсэлд тавигддаг PCI:DSS стандартыг нэвтрүүлээд байна.

## БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЦААШДЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Инновэйшн Инвестмент компани нь Тогтвортой хөгжил, нийгэм, байгаль орчны нөлөөллийн бодлогын хүрээнд дараах гурван чиглэлийг баримталж, зохих хөтөлбөр, журам, шийдэл хэрэгжүүлэх замаар үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллахаар төлөвлөж байна:

E – Байгаль орчин:

• Цахим төлбөрийн хэрэгслийн хэрэглээг сурталчлан Хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлснээр байгаль орчны бохирдол, хог хаягдлыг бууруулах;
• Байгаль орчин экологийн тэнцвэрт байдлыг хадгалах зорилго бүхий төслүүдэд хөрөнгө оруулах, үйл ажиллагааг дэмжих;
• Байгууллагын дотоод үйл ажиллагаанд хог хаягдлыг ялгах зуршлыг бий болгох;
• Байгууллагын усны хэрэглээг багасгах шийдлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;
• Сэргээгдэх эрчим хүчний шийдлийг ашиглах, бусдыг уриалах.

S – Нийгэм, эдийн засаг:

• Нийгэмд чиглэсэн эерэг үйл ажиллагаа болон төслүүдийг дэмжин ажиллах;
• Нийгмийн хариуцлагын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ажлын байр бий болгох;
• Байгууллагын ажлын байрны тоог тогтвортой өсгөх бодлого баримтлах;
• Төрийн үйлчилгээний төлбөрийн шийдлийг улам хялбар болгох, хэрэглээг нэмэгдүүлэх.

G – Засаглал:

• Байгууллагын ажилтны жендерийн харьцаа болон эрхийн тэгш байдлыг хадгалах;
• Харилцагчид болон түнш байгууллагуудын харилцааг бэхжүүлэх арга хэмжээ авах;
• Байгууллагын тогтвортой хөгжлийн тайлан гаргах

# 03. САНХҮҮГИЙН ТАЙЛАН

*Аудитын дүгнэлт*

*Санхүү байдлын тайлан*

*Орлого үр дүнгийн тайлан*

*Өмчийн өөрчлөлтийн тайлан*

*Мөнгөн гүйлгээний тайлан*

# 01. АУДИТЫН ДҮГНЭЛТ

Grant Thornton

**"ГРАНТ ТОРНТОН АУДИТ" ХХК**
Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний дэлхийн сүлжээний бие даасан фирм

Далай тауэр, 9 давхар,
ЮНЕСКО гудамж - 31,
Сүхбаатар дүүрэг,
1 хороо Улаанбаатар
14230, Монгол улс
T + 976 70 110744
+ 976 70 110799

Dalai Tower, 9 floor,
UNESCO street - 31,
Sukhbaatar District-1,
Ulaanbaatar 14230,
Mongolia
T + 976 70 110744
+ 976 70 110799

## Хараат бус аудиторын дүгнэлт

**"Инновэйшн Инвестмент" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:**

### *Зөрчилгүй дүгнэлт*

Бид "Инновэйшн Инвестмент" ХХК, түүний охин компаниуд (цаашид "групп" гэх)-ын 2023 оны 12 дугаар сарын 31-нээрх нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад (цаашид "Нэгтгэсэн санхүүгийн тайлан" гэх)-д аудит хийлээ. Үүнд:

- Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан,
- Нэгтгэсэн ашиг алдагдал, ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан,
- Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан,
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон
- Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй,
- Бусад тайлбар тодруулгууд

Бидний дүгнэлтээр "Инновэйшн Инвестмент" ХХК, түүний охин компаниудын 2023 оны 12 дугаар сарын 31-нээрх нэгтгэсэн санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

### *Дүгнэлтийн үндэслэл*

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага* гэсэн хэсэгт харуулав.

### *Хараат бус байдал*

Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус группээс хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, зохистой гэж итгэж байна.

# 01. АУДИТЫН ДҮГНЭЛТ

Grant Thornton

*Аудитын аргачлалын хураангуй*

| | |
|---|---|
| **Аудитын гол асуудлууд** | • Орлого нь группийн санхүүгийн тайлангийн чухал үзүүлэлт бөгөөд "QPAY" системээр үзүүлж буй үйлчилгээний хүрээнд зарим харилцагч арилжааны банк болон компани хоорондын тооцооллыг автоматжуулаагүй, гэрээний нөхцөлийн дагуу гарсан зарим гүйлгээнээс өөрт ногдох орлогыг тодорхойлохдоо гар аргаар тооцоолол хийж байгаа зэргийг харгалзаж аудитын гол асуудалд тусгав. |
| **Аудитын цар хүрээ** | • Энэхүү аудитын цар хүрээнд тус компанийн охин компаниуд болох "ККТТ" ХХК болон "Дижитал Мерчант Сервисэс" ХХК-ийн тусдаа санхүүгийн тайлангууд багтсан болно. |
| **Материаллаг байдал** | • Санхүүгийн тайлангийн аудитад ашигласан нийт материаллаг байдал нь 191,406.9 мянган төгрөг ба материаллаг байдлыг сонгохдоо татварын өмнөх ашгийн 3%-иар тооцсон.<br>• Группийн голлох бизнесийн үйл ажиллагаа нь ашиг орлого олох бөгөөд санхүүгийн тайлангийн үндсэн хэрэглэгчдийн анхаарлыг хандуулах үзүүлэлт учир татвар төлөхийн өмнөх ашгийг материаллагийн суурь үзүүлэлтээр сонгосон.<br>• Гүйцэтгэлийн материаллаг байдлыг нийт материаллаг байдлын дүнгийн 75 хувиар буюу 143,555.2 мянган төгрөгөөр тогтоосон нь Группийн дотоод хяналтын орчныг дунд гэж үнэлсэнтэй холбоотой. |

*Аудитын гол асуудлууд*

Бидний мэргэжлийн шийдлээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Эдгээрт залилангаас үүдсэн материаллаг буруу тайлагналын эрсдэлийг багтаасан нөлөө бүхий эрсдэлүүдийг хамруулдаг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд доорх асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын агуулгын хүрээнд бүхэлд нь болон аудиторын дүгнэлт гаргахад авч үзсэн. Доорх хураангуй хүснэгтэд эдгээр эрсдэлд авсан аудиторын хариу арга хэмжээг харуулав. Бид эдгээр асуудалтай холбоотойгоор дүгнэлтээ хязгаарлаагүй болно.

| Орлогыг хүлээн зөвшөөрөх тооцооллын хүндрэлтэй асуудал | Эрсдэлд авсан хариу арга хэмжээ |
|---|---|
| Группийн үндсэн үйл ажиллагааны орлого нь QR код бүхий нааэлтыг ашиглан эцсийн хэрэглэгчээс шилжүүлсэн төлбөрийн шимтгэлийн орлого юм.<br><br>Тухайн QR код бүхий наалтыг ашиглан худалдан авагч төлбөр шилжүүлэх үед группийн харилцагч байгууллагууд болох мерчант байгууллагууд, арилжааны банкууд, бусад харилцагч нартай байгуулсан гэрээний нөхцөлөөс хамааран шимтгэлийн орлого группийн харилцах дансанд шууд болон дараа тооцоот хэлбэрээр төвлөрүүлэн, орлогыг аккруэль сууриар хүлээн зөвшөөрдөг.<br><br>Орлого нь группийн санхүүгийн тайлангийн гол үзүүлэлтүүдийн нэг бөгөөд "QPAY" систем нь зарим харилцагч арилжааны банк болон | Бид группийн орлого хүлээн зөвшөөрөлттэй холбоотой процессийн талаар ойлголтоо баримтжуулж, энэ процесстэй холбоотой дотоод хяналтын гол элементүүдийг тодорхойлсон.<br><br>Орлого хүлээн зөвшөөрөлттэй холбоотой дараах горимуудыг гүйцэтгэсэн. Үүнд:<br>• Орлого хүлээн зөвшөөрөлт болон холбогдох тооцоолол, шийдэл зэргийг хамруулсан бүртгэлийн бодлогыг шалгасан.<br>• QR код бүхий наалтыг ашиглан худалдан авагч төлбөр шилжүүлэх үед харилцагч байгууллагууд болох арилжааны банкууд бусад харилцагч нартай байгуулсан гэрээний заалтын дагуу тооцоолсон удирдлагын тооцооллыг шалгах нарийвчилсан тестүүдийг гүйцэтгэсэн, |

# 01. АУДИТЫН ДҮГНЭЛТ

Grant Thornton

| | |
|---|---|
| гарсан гүйлгээнээс өөрт ноогдох орлогыг тодорхойлохдоо гар аргаар тооцоолол хийж байгаа зэргийг харгалзаж аудитын гол асуудалд тусгав.<br>Орлогын тодруулгыг энэхүү тайлангийн **Тодруулга 21-д** толилуулсан. | • СТОУС 15 *"Харилцагчтай хийсэн гэрээний орлого"*-н хэрэгжүүлэлттэй холбоотой хяналтын загварчлал болон хэрэгжүүлэлтийг үнэлсэн,<br>• Гэрээний орлогын дүнг түүвэрлэн давтан тооцоолсон.<br>• Орлоготой холбоотой тооцоололд ашигласан өгөгдлийн бүрэн байдлыг шалгасан. |

### *Бусад мэдээлэл*

Удирдлага бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээнэ. Группийн 2023 оны 12 дугаар сарын 31-нээрх жилийн нэгтгэсэн тайланд багтсан мэдээллээс бүрдэх ба харин санхүүгийн тайлан болон манай аудиторын тайланг багтаахгүй. Жилийн тайлан нь энэхүү аудиторын тайлан гарсан өдрөөс хойш бидэнд нээлттэй болно.

Нэгтгэсэн санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бусад мэдээллийн талаарх аливаа баталгаажуулалтын дүгнэлт илэрхийлэхгүй.

### *Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн нэгтгэсэн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага*

Группийн удирдлага эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг зохистой данс бүртгэлд тулгуурлан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Түүнчлэн нэгтгэсэн санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай дотоод хяналтыг бүрдүүлэх нь группийн удирдлагын үүрэг хариуцлага байдаг.

Удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ группийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах группийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь группийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### *Санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага*

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс нэгтгэсэн санхүүгийн тайланг нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

### *Аудитор нь залилан зэрэг хууль бус асуудлуудыг илрүүлэх чадавхийг ямар цар хүрээнд авч үзсэн талаарх тайлбар*

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас нэгтгэсэн санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын баримт нотолгоо олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас

# 01. АУДИТЫН ДҮГНЭЛТ

Grant Thornton

үүсэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.

- Группийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор буюу тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн группийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал групп тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж нэгтгэсэн санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц дутагдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий удирдлагатай харилцдаг.

Бид хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн гэдгээ засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд мэдэгддэг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл холбогдох хамгаалалт зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг. Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайландаа аливаа асуудлаар харилцах нь тухайн харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай учраас аудиторын тайландаа харилцахгүй байх нь зүйтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог.

### *Аудитын тайлангийн хэрэглээ*

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу зөвхөн группийн хувьцаа эзэмшигчдэд зориулсан ба бусад өөр этгээдэд зориулаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

Энэхүү Хараат бус аудиторын тайланг гаргахад оролцсон Гэрээт ажлын партнер нь Н.Эрдэнэцог болно.

GRANT THORNTON AUDIT LLC
ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
1118276081 2577542

Б.ОСОРГАРАВ
УДИРДАХ ПАРТНЕР

Огноо: 2024.03.22

Н.ЭРДЭНЭЦОГ
ГЭРЭЭТ АЖЛЫН ПАРТНЕР

Огноо: 2024.03.22

# 02. САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

| *МЯНГАН ТӨГРӨГӨӨР* | 2023 үлдэгдэл | 2022 үлдэгдэл |
|---|---|---|
| **Эргэлтийн хөрөнгө** | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 13,999,820 | 1,853,360 |
| Дансны ба бусад авлага | 1,857,950 | 1,102,693 |
| Богино хугацаат санхүүгийн хөрөнгө | 1,924,531 | 2,412,454 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 80,548 | 330,842 |
| Бараа материал | 2,020 | 150 |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 17,864,869 | ***5,699,499*** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| Үндсэн хөрөнгө | 584,300 | 694,476 |
| Ашиглах эрхтэй хөрөнгө | 39,774 | 128,060 |
| Биет бус хөрөнгө | 216,070 | 234,051 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | 58,711 | - |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 898,855 | ***1,056,587*** |
| ***Нийт хөрөнгө*** | ***18,763,724*** | ***6,756,086*** |
| **ӨР ТӨЛБӨР БОЛОН ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ** | | |
| **Эргэлтийн өр төлбөр** | | |
| Дансны ба бусад өглөг | 1,277,368 | 480,266 |
| Санхүүгийн түрээсийн өр төлбөр | 617 | 1,047 |
| Урьдчилж орсон орлого | 1,800 | - |
| Эргэлтийн өр төлбөрийн дүн | 1,279,785 | ***481,313*** |
| **Эргэлтийн бус өр төлбөр** | | |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | - | 4,615 |
| Санхүүгийн түрээсийн урт хугацаат өр төлбөр | 36,372 | 100,997 |
| Эргэлтийн бус өр төлбөрийн дүн | 36,372 | ***105,612*** |
| Өр төлбөрийн дүн | 1,316,156 | ***586,925*** |
| **Эзэмшигчдийн өмч** | | |
| Хувьцаат капитал | 4,425,440 | 3,501,000 |
| Нэмж төлөгдсөн капитал | 4,653,188 | - |
| Хуримтлагдсан ашиг/(алдагдал) | 8,368,939 | 2,668,161 |
| Эздийн өмчийн дүн | 17,447,568 | ***6,169,161*** |
| ***Нийт өр төлбөр болон эзэмшигчдийн өмч*** | ***18,763,724*** | ***6,756,086*** |

# 03. ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

| *МЯНГАН ТӨГРӨГӨӨР* | 2023 үлдэгдэл | 2022 үлдэгдэл |
|---|---|---|
| Шимтгэлийн орлого | 13,237,510 | 6,341,734 |
| Өртөг | (6,041,015) | (1,124,229) |
| Нийт ашиг/(алдагдал) | 7,196,496 | ***5,217,505*** |
| Борлуулалт, маркетингийн зардал | (564,484) | (262,537) |
| Ерөнхий удирдлагын зардал | (1,698,693) | (1,291,265) |
| Бусад орлого | 1,210,184 | - |
| Бусад зардал | (161,084) | (17,973) |
| Үндсэн үйл ажиллагааны үр дүн | 5,982,418 | 3,645,730 |
| Санхүүгийн орлого | 414,802 | 96,960 |
| Санхүүгийн зардал | (12,897) | (20,388) |
| Үндсэн хөрөнгө борлуулсаны олз | 74 | 8,649 |
| Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг/алдагдал | (4,164) | 159,213 |
| Бусад ашиг/алдагдал | - | (15,986) |
| Орлогын татварын өмнөх ашиг/(алдагдал) | 6,380,232 | 3,874,178 |
| Орлогын татварын зардал/(буцаалт) | (684,069) | (401,167) |
| ***Тайлант жилийн ашиг/(алдагдал)*** | ***5,696,163*** | ***3,473,012*** |

# 04. НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| МЯНГАН ТӨГРӨГӨӨР | Хувьцаат капитал | Нэмж төлөгдсөн капитал | Хуримтлагдсан ашиг/(алдагдал) | Нийт |
|---|---|---|---|---|
| **2021 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл** | **3,501,000** | **-** | **(804,851)** | **2,696,149** |
| Тайлант жилийн ашиг **(алдагдал)** | | - | 3,473,012 | 3,473,012 |
| Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - | - |
| **2022 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл** | **3,501,000** | **-** | **2,668,161** | **6,169,161** |
| НББ-ийн тооцооллын өөрчлөлт | - | - | 4,615 | 4,615 |
| Залруулсан үлдэгдэл | 3,501,000 | - | 2,672,776 | 6,173,776 |
| Тайлант жилийн ашиг **(алдагдал)** | - | - | 5,696,163 | 5,696,163 |
| Өмчид гарсан өөрчлөлт (тодруулга 20) | 924,440 | 4,653,188 | - | 5,577,629 |
| ***2023 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл*** | ***4,425,440*** | ***4,653,188*** | ***8,368,939*** | ***17,447,568*** |

# 05. НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| *МЯНГАН ТӨГРӨГӨӨР* | | 2023 үлдэгдэл | 2022 үлдэгдэл |
|---|---|---|---|
| ***ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ*** | | | |
| Мөнгөн орлогын дүн | | 14,678,300 | ***7,322,747*** |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэн орлого | | 13,761,945 | 6,725,328 |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | | 35 | 433 |
| Буцаан авсан албан татвар | | 47,795 | - |
| Бусад мөнгөн орлого | | 868,526 | 596,986 |
| Мөнгөн зарлагын дүн | | 11,709,895 | ***4,314,744*** |
| Ажиллагчдад төлсөн | | 1,279,773 | 819,075 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | | 340,015 | 215,158 |
| Бараа материал худалдан авахад төлсөн | | 9,472 | 395,607 |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | | 157 | - |
| Татварын байгууллагад төлсөн | | 1,668,329 | 1,009,479 |
| Даатгалын төлбөрт төлсөн | | 2,813 | 2,865 |
| Бусад мөнгөн зарлага | | 8,409,338 | 1,872,560 |
| ***Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн*** | | ***2,968,406*** | ***3,008,003*** |
| ***ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ*** | | | |
| **Мөнгөн орлогын дүн** | | **4,452,375** | **242,930** |
| Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | | - | 15,150 |
| Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | | 3,992,456 | - |
| Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | | 46,916 | 193,218 |
| Хүлээн авсан хүүний орлого | | 413,003 | 34,562 |
| **Мөнгөн зарлагын дүн** | | **3,882,164** | **3,603,007** |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | 81,032 | 762,567 |
| Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | - | 26,186 |
| Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | | 3,653,247 | 2,412,454 |
| Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | | 147,885 | 401,800 |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | | 570,211 | (3,360,077) |
| ***САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ*** | | | |
| Мөнгөн орлогын дүн | | 8,747,873 | 471 |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | | 10 | 471 |
| Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | | 8,747,864 | - |
| ***Мөнгөн зарлагын дүн*** | | ***136,283*** | ***77,634*** |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | | - | 45,613 |
| Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | | 136,283 | 32,021 |
| Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | | 8,611,591 | (77,163) |
| ***САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ*** | | | |
| Валютын ханшийн зөрүү | | (3,748) | 159,178 |
| ***Бүх цэвэр мөнгөн гүйлгээ*** | | ***12,146,460*** | ***(270,058)*** |
| ***Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл*** | | ***1,853,360*** | ***2,123,419*** |
| ***Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл*** | | ***13,999,820*** | ***1,853,360*** |

# 04. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

*Хувьцаа эзэмшигчдийн хурал*

*Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал, үйл ажиллагаа*

*Хувьцааны ханш*

*Ногдол ашгийн бодлогын хэрэгжилт*

## КОМПАНИ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Оноосон нэр:
**QPAY**

Хэлбэр:
**Хязгаарлагдмал хувьцаат компани**

Регистрийн дугаар:
**6183948**

Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгуулага:
**Монголын Хөрөнгийн бирж**

МХБ-ийн хувьцааны бүртгэлийн ангилал:
**III**

Гаргасан нийт хувьцааны тоо ширхэг:
**184,889,160**

Бизнесийн үндсэн үйл ажиллагааны салбар:

- **Мэдээлэл технологийн үйл ажиллагаа**
- **Программ хангамжийн үйлчилгээ**

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Хувьцаа эзэмшигчдийн тоо:
**1.193 ширхэг хувьцаа эзэмшигч**

Хувьцааны эзэмчигчдийн бүтэц:



**20 %** Олон нийт

**18 %** ICT GROUP “Ай Си Ти Групп” ХК

**8.42 %** UNIMEDIA SOLUTIONS “Юнимедиа Солюшнс” ХХК

**7.59 %** “Айкор Партнерс” ХХК

**8.98 %** Чойжоохүү Нарангэрэл

**5.61 %** “Рентракс” ХК

**31.04 %** Бусад хувьцаа эзэмшигчид

## 01. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Инновэйшн Инвестмент ХХК нь 2023 оны 4 дүгээр сарын -26ны өдөр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хийсэн. Тус хурлаар Компанийн жилийн үйл ажиллагааны болон аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт батлах болон IPO хийх тухай зэрэг үндсэн асуудлуудыг баталж шийдвэр гаргасан.

## 02. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2020 оны 08 дугаар сарын -20ны өдөр батлагдсан "ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"- ыг дагаж мөрдөж байна. Тус журамд ТУЗ-ийн бүрэн эрх, ТУЗ-ийн бүрэлдэхүүн, нэр дэвшүүлэх, гишүүн сонгох, чөлөөлөх, ТУЗ-ийн гишүүний эрх, үүрэг, ТУЗ-ийн дарга, түүний бүрэн эрх, ТУЗ-ийн хурал, хуралдах журам, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, түүний бүрэн эрх, ТУЗ-ийн зардал, үйл ажиллагааг дүгнэх, ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулсан байдаг.

ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 9.2 дах хэсэгт заасны дагуу ТУЗ-ийн дэргэд дор дурдсан хороод ажиллаж байна. Үүнд:

1. Аудит, эрсдэлийн хороо
2. Цалин урамшуулал, нэр дэвшүүлэлтийн хороо
3. Стратеги бизнес хөгжилийн хороо

## ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН



**Д.ДАВАА**
*ТУЗ-ийн дарга*



**Б.ЧУЛУУНСҮХ**
*ТУЗ-ийн гишүүн*



**Э.АМАРЖАРГАЛ**
*ТУЗ-ийн нарийн бичгийн дарга*



**У.НАРАНБААТАР**
*ТУЗ-ийн гишүүн*



**ХОСОКАВА МАСАХИКО**
*ТУЗ-ийн гишүүн*



**А.БАТТАМИР**
*ТУЗ-ийн гишүүн*



**Г.ЛХАМСҮРЭН**
*ТУЗ-ийн гишүүн*



**Б.АНХБОЛД**
*ТУЗ-ийн гишүүн*

# 03. ХУВЬЦААНЫ ХАНШ

Инновэйшн Инвестмент ХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 11 дүгээр сарын -8ны өдрийн 551 тоот тогтоолоор IPO хийх зөвшөөрөл авч, 2023 оны 12 дугаар сарын -4ний өдөр олон нийтэд компанийн 20 хувь буюу 36,977,618 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 225 төгрөгөөр санал болгосон. Анхдагч арилжаа амжилттай явагдаж 8.3 тэрбум төгрөгийг олон нийтээс татан төвлөрүүлж, 1,155 хувьцаа эзэмшигчтэй болсон. Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа МХБ-ийн III ангилал дээр 2023 оны -12р сарын 20 өдөрөөс эхэлсэн. 2023 он дуустал буюу 7 хоногийн хугацаанд хувьцааны арилжаа идэвхтэй байсан




# 04. НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭ




### *НОГДОЛ АШИГ:*

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 2 сарын -15ны өдрийн 02/02 тоот тогтоолоор хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн. Үүнд: Инновэйшн Инвестмент ХК-ийн 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 21.63 /хорин нэгэн төгрөг жаран гурван мөнгө/ төгрөгөөр тогтоож, Компанийн 2023 оны цэвэр ашгийн 70.2 /дал аравны хоёр/ хувь буюу 4,000,000,000.00 /дөрвөн тэрбум/ төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлэсэн. СЗХ-ны 2024 оны 2 дугаар сарын -27ны өдрийн 712/3 тоот тогтоолын дагуу тус ногдол ашгийг 2024 оны 4 дүгээр сарын -30ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулж хуваарилахаар төлөвлөж байна.

*Вэб хуудас: I-INVESTMENT.MN*
*Холбоо барих: +976 76102211*
*И-мэйл хаяг: INFO@QPAY.MN*
*Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Элчингийн гудамж, Шүрэн оффис, 6 тоот*

*Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4 дүгээр хавсралт*

**Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/**

*Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.*

| | |
|---|---|
| Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/ | 2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр |
| Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар | Нэр: Инновэйшн Инвестмент<br>УБ-ийн гэрчилгээний дугаар: 9019097177<br>Үнэт цаасны код: QPAY<br>Утасны дугаар: 76102211 |
| Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр | Монголын хөрөнгийн бирж |
| Бизнесийн үйл ажиллагааны салбар | Мэдээлэл технологийн үйл ажиллагаа<br>Программ хангамжийн үйлчилгээ |
| Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо | Грант торнтон аудит ХХК<br>СЗХ-нд бүртгүүлсэн огноо 2021.12.14 |
| Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг | 184,889,160 ширхэг |
| Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр | Санхүү эрхэлсэн захирал Б.Энхболд |

| | |
|---|---|
| 1. | Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/ |

Санхүүгийн байдлын үзүүлэлт

| Үзүүлэлт | 2023 он /мян.төг/ | 2022 он /мян.төг/ |
|---|---|---|
| **Хөрөнгө** | | |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 17,864,869 | 5,699,499 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 898,855 | 1,056,587 |
| **Нийт хөрөнгө** | **18,763,724** | **6,756,086** |
| **Өр төлбөр ба эздийн өмч** | | |
| Богино хугацаат өр төлбөр | 1,279,785 | 481,313 |
| Урт хугацаат өр төлбөр | 36,372 | 105,612 |
| **Нийт өр төлбөр** | **1,316,156** | **586,925** |
| Эздийн өмчийн дүн | 17,447,568 | 6,169,161 |
| **Нийт өр төлбөр болон эздийн өмчийн дүн** | **18,763,724** | **6,756,086** |

Орлогын тайлан

| Үзүүлэлт | 2023 он /мян.төг/ | 2022 он /мян.төг/ |
|---|---|---|
| Борлуулалтын орлого | 13,237,510 | 6,341,734 |
| Өртөг | (6,041,015) | (1,124,229) |
| **Нийт ашиг/(алдагдал)** | **7,196,496** | **5,217,505** |
| Борлуулалт, маркетингийн зардал | (564,484) | (262,537) |
| Ерөнхий удирдлагын зардал | (1,698,693) | (1,291,265) |
| Бусад орлого | 1,210,184 | - |
| Бусад зардал | (161,084) | (17,973) |
| **Үндсэн үйл ажиллагааны үр дүн** | **5,982,418** | **3,645,730** |
| Санхүүгийн орлого | 414,802 | 96,960 |
| Санхүүгийн зардал | (12,897) | (20,388) |
| Үндсэн хөрөнгө борлуулсаны олз | 74 | 8,649 |
| Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг/алдагдал | (4,164) | 159,213 |
| Бусад ашиг/алдагдал | - | (15,986) |
| **Орлогын татварын өмнөх ашиг/(алдагдал)** | **6,380,232** | **3,874,178** |
| Орлогын татварын зардал/(буцаалт) | (684,069) | (401,167) |
| **Тайлант жилийн ашиг/(алдагдал)** | **5,696,163** | **3,473,012** |

| | | |
|---|---|---|
| | Өмчийн өөрчлөлтийн тайлан | (see table below) |

| Үзүүлэлт | Нийт /мян.төг/ |
|---|---|
| **2021 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл** | **2,696,149** |
| Тайлант жилийн алдагдал | 3,473,012 |
| **2022 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл** | **6,169,161** |
| НББ-ийн тооцооллын өөрчлөлт | 4,615 |
| **Залруулсан үлдэгдэл** | **6,173,776** |
| Тайлант жилийн алдагдал | 5,696,163 |
| Өмчид гарсан өөрчлөлт | 5,577,629 |
| **2023 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл** | **17,447,568** |

Мөнгөн гүйлгээний тайлан

| Үзүүлэлт | 2023 он /мян.төг/ | 2022 он /мян.төг/ |
|---|---|---|
| Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 2,968,406 | 3,008,003 |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 570,211 | (3,360,077) |
| Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 8,611,591 | (77,163) |
| Валютын ханшийн зөрүү | (3,748) | 159,178 |
| Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 12,146,460 | (270,058) |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **1,853,360** | **2,123,419** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **13,999,820** | **1,853,360** |

Тайланг хавсралтаар хүргүүлэв.

1.1. Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт

Аудитын дүгнэлтийг хавсралтаар хүргүүлэв.

1.2. Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/

Аудитын дүгнэлтийг хавсралтаар хүргүүлэв.

2. Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл

2.1. Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/

| Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд | 2023 | 2022 |
|---|---|---|
| Нийт ашгийн хувь | 54% | 82% |
| Үйл ажиллагааны ашгийн хувь | 45% | 57% |
| Цэвэр ашгийн хувь | 43% | 55% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж | 33% | 56% |
| Нэгж хувьцаанд ногдох ашиг | 30.81 | 24.80 |

| | | |
|---|---|---|
| 2.2. | Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт | (see nested table below) |

| Хөрвөх чадварын харьцаа | 2023 | 2022 |
|---|---|---|
| Эргэлтийн харьцаа | 13.96 | 11.84 |
| Түргэн хөрвөх чадварын харьцаа | 13.96 | 11.84 |
| Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа | 7.54% | 9.51% |

2.3. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт ээлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл

Монгол Улсын төлбөрийн системийн эрх зүйн орчныг шинэчлэх ажлын хүрээнд "Үндэсний төлбөрийн системийн тухай хууль" 2017 оны 5 дугаар сарын 31-нд батлагдаж, 2018 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөгдөж эхэлсэн. Энэ хууль нь Монгол Улсын үндэсний төлбөрийн системийг удирдах, зохион байгуулах, зохицуулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахаас гадна Үндэсний төлбөрийн системд банкнаас бусад этгээд оролцох боломжийг нээж өгсөн байдаг.

Төлбөр тооцооны системийн үндсэн зорилго нь банк, санхүүгийн салбарт хийгдэж буй төлбөр тооцоог тасралтгүй, найдвартай, шуурхай гүйцэтгэх замаар нийт эдийн засаг дахь мөнгөний эргэлтийг хурдасгах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах явдал юм. Иймд төлбөрийн систем нь санхүүгийн системийн дэд бүтцийн чухал хэсэг төдийгүй мөнгөний бодлогыг дамжуулах гол суваг болж үйлчилдэг. Сүүлийн жилүүдэд өндөр түвшний технологи нэвтрэхтэй зэрэгцэн зах зээлийн хөгжлийн хандлага, эрэлт шаардлагад нийцсэн бэлэн бус төлбөрийн шинэ дэвшилтэт хэрэгслүүд хурдацтайгаар бий болж, төлбөр тооцоог түргэн шуурхай, үр ашигтай гүйцэтгэх боломж бүхий шинэ системүүдийг нэвтрүүлэхэд хүргэсэн. Эдгээр системийн үр ашигтай, хэвийн ажиллагаа нь байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн, бизнес эрхлэгчдэд санхүүгийн үүргээ биелүүлэх, мөнгөн хөрөнгөө аюулгүй, цаг тухайд нь шилжүүлэх боломжийг олгож байна.

Монгол улсын бэлэн бус төлбөр тооцооны зах зээлийн түүхэн үзүүлэлтийг дараах графикт харууллаа. Үүнд: Интернет банк, мобайл банк, телефон банк болон картаар хийгдэж буй бүх гүйлгээнүүдийг оруулж тооцсон.




Эх сурвалж: Монгол банк

2017 онд 321 сая ширхэг гүйлгээ бэлэн бусаар хийгдэж байсан бол 2023 оны эхний 3 улирлын байдлаар нийт бэлэн бус гүйлгээний тоо 1.3 их наяд ширхэгт хүрч 4.1 дахин өссөн бол үнийн дүнгийн хувьд 76 их наяд төгрөгөөс 325 их наяд төгрөгт хүрч 4.3 дахинаар өссөн байна. Гэсэн хэдий ч иргэд АТМ-ээс бэлэн мөнгө гарган өдөр тутмын хэрэглээ, худалдан авалт, үйлчилгээндээ ашигласан хэвээр байгаа юм. АТМ-ээс бэлнээр гаргасан мөнгийг иргэд хэд хэдэн удаа үйлчилгээнд ашиглан дамжуулсны эцэст буцаж банканд ирдэг. Бэлэн мөнгөний хэрэглээг улам бууруулвал бэлэн бус гүйлгээний тоо нэлээд хувиар цаашид өсөх боломж их байна.

Хэрэглэгчдийн хувьд цаашид бэлэн бусаар төлөх дадал улам нэмэгдэж байгаа бөгөөд байгууллагууд түүнд нийцсэн шинэ үйлчилгээнүүдийг ихээр бий болгож зах зээл нэлээд тэлэх төлөвтэй байна.

Ийнхүү Монгол Улсын төлбөр тооцооны салбарт дижитал төлбөрийн хэрэгсэл илүү нэвтэрч, хэрэглэгчид бэлэн бусаар төлбөр тооцоо гүйцэтгэх хандлага нэмэгдэж байгаад дараах хүчин зүйлс томоохон нөлөөллийг үзүүлж байна. Үүнд:

• Хэрэглэгчид өдөр тутамдаа ашиглахад хялбар, хурдан, найдвартай төлбөрийн шийдлүүдийг ашиглах сонирхол нэмэгдэж, бэлэн төлбөр тооцооноос бэлэн бус руу шилжих хандлага нэмэгдэж байна.

| | | |
|---|---|---|
| | | • КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэхийн тулд иргэд худалдан авах зан төлөвөө өөрчилж, бэлэн мөнгөөр худалдан авалт хийхээс зайлсхийж аппликэйшн ашиглахыг илүүд үзэх болсон.<br><br>• Монгол улсад гар утасны хэрэглээ болон 3G, 4G сүлжээ өргөн хэрэглээнд нэвтэрсэн тул иргэд аппликэйшн, интернэт банк ашиглахад хялбар нөхцөл байдал бүрдсэн. Үүнтэй зэрэгцэн бизнес хэрэглэгчид цахим төлбөр тооцоо бүхий шийдлүүдийг санал болгохыг эрмэлзэх болсон.<br><br>• Олон улсын зохицуулах байгууллагууд адил Монголбанк нь төлбөр тооцооны системүүдийн найдвартай, тогтвортой, үр ашигтай ажиллагааг хангах, бэлэн бус төлбөрийн хэрэглээг дэмжих, санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх бодлого баримтлан ажиллаж байна.<br><br>• Бизнес эрхлэгчид төлбөрийн зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, төлбөрийн шийдлийн уян хатан байдалд ач холбогдол өгч, харилцагчдынхаа таашаалд нийцсэн шийдлүүдийг илүү эрэлхийлэх хандлагатай байна.<br><br>Бидний хувьд төлбөрийн зах зээл дээр QPay үйлчилгээний цар хүрээг улам өргөжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2023 онд Голомт банкны Social Pay-тэй холболт хийж, харилцан уншдаг болсоноор Монголын арилжааны бүх банкуудад нэвтрээд байна. Үүний үр дүнд QR төлбөр тооцооны зах зээлийг бүрэн хамарч хэрэглэгчид болон мерчант байгууллагууд дурын банкны дансаа ашиглан QPay-ээр төлбөр тооцоогоо хийх боломжтой боллоо.<br><br>Гэсэн хэдий ч Монгол улсын нийт бэлэн бус төлбөрийн зах зээлд QPay үйлчилгээний эзлэх хувь хэмжээ харьцангуй бага байгаа нь цаашид өсөх боломж нэлээдгүй байгааг харуулж байна.<br><br><br><br>QPay үйлчилгээгээр хийгдэж буй гүйлгээнүүд нь 2022 оны эцсээр энэхүү зах зээлийн 4.1 хувийг эзэлж байсан бол 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 6.5 хувьд хүрч өссөн байна.<br><br>Бидний хувьд Монгол банкнаас баталсан QR-ийн шинэ стандартыг 2023 онд бүрэн хангасан ба дотоодын QR төлбөр тооцооны зах зээл дээрх байр сууриа улам бэхжүүлэн ажиллаж байна. Мөн олон улсын зах зээл дээр буюу Хятад, Солонгос улсын компаниудтай хамтран төлбөр тооцооны үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. |
| 2.4. | Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/ | Байхгүй. |
| 2.5. | Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл; | Зээлийн өр төлбөр байхгүй. |

| | |
|---|---|
| 3. | Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/ |
| | Байхгүй. |
| 4. | Цалин урамшууллын мэдээлэл |
| | Компани нь голлох удирдлагуудад олгох цалин хөлс, урамшуулал, тэтгэмжийн асуудлыг Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох дүрэм журам, Инновэйшн Инвестмент ХК-ийн "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 14 дүгээр бүлэг, Хувьцаа эзэмшигчийн хурлын шийдвэр, Төлөөлөн удирдах зөвлөлийн Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээний хүрээнд тооцон олгож байна.<br><br>Голлох удирдлагад ТУЗ-ын дарга, гишүүд болон гүйцэтгэх удирдлага, тэдгээрийн гэр бүлийн гишүүд хамаарна.<br><br>Тайлант онд Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшуулалд 318.035 мянган төгрөг, Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин, урамшуулалд 148,433 мянган төгрөгийг зарцуулан тайлагнасан.<br><br>Голлох удирдлагын цалин хөлс, урамшуулалын зардалыг доорх хүснэгтэд харуулав. |
| 5. | Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл |

| Цалин урамшуулал | Гүйцэтгэх удирдлага | Төлөөлөн удирдах зөвлөл |
|---|---|---|
| Цалин | 181,337 | 96,000 |
| Урамшуулал | 136,698 | 52,433 |
| **Нийт** | **318,035** | **148,433** |

**Төлөөлөн удирдах зөвлөл**

Инновэйшн Инвестмент ХХК нь 2023 оны 12 дугаар сард IPO хийж нээлттэй хувьцаат компани болсон бөгөөд хувьцаа эзэмшигчдийн анхдугаар хурлаа 2024 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр хийхээр төлөвлөж байна. Тус хурлаар ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгох ба хуулийн дагуу хараат бус гишүүд мөн томилогдох юм.

Компанийн одоогийн ТУЗ нь дараах бүтэц бүрэлдэхүүнтэй байна.
Инновэйшн Инвестмент ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн ээлжит хурлын 03/2020 тоот тогтоолоор ТУЗ нь 7 ердийн гишүүнтэй байхаар шийдвэрлэсэн бөгөөд ТУЗ-ийн гишүүд нь Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн хурлын 23/08 тоот тогтоолын дагуу томилогдон ажиллаж байна.

Компанийн ТУЗ нь Монгол Улсын болон Япон Улсын мэдээллийн технологи, банк, санхүүгийн салбаруудад 10 - 30 гаруй жил ажилласан инженер, бизнес удирдлагаар мэргэшсэн арвин туршлага бүхий гишүүдээс бүрддэг.

ТУЗ-ийн дарга Д.Даваа
ТУЗ-ийн гишүүн Б.Чулуунсүх
ТУЗ-ийн гишүүн Хосокава Масахико
ТУЗ-ийн гишүүн У.Наранбаатар
ТУЗ-ийн гишүүн Б.Анхболд
ТУЗ-ийн гишүүн А.Баттамир
ТУЗ-ийн гишүүн Г.Лхамсүрэн
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Э.Амаржаргал

Компани нь өөрийн засаглалын үйл ажиллагаандаа Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа, түүний дэргэдэх хороодын бүтэц зохион байгуулалтын үйл ажиллагааны журмыг зохицуулсан "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг дагаж мөрдөж байна. Тус журамд ТУЗ-ийн бүрэн эрх, ТУЗ-ийн бүрэлдэхүүн, нэр дэвшүүлэх, гишүүн сонгох, чөлөөлөх, ТУЗ-ийн гишүүний эрх, үүрэг, ТУЗ-ийн дарга, түүний бүрэн эрх, ТУЗ-ийн хурал, хуралдах журам, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, түүний бүрэн эрх, ТУЗ-ийн зардал, үйл ажиллагааг дүгнэх, ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулсан байна. ТУЗ-ийн дэргэдэх дараах хороод ажиллаж байна.




Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь сар бүр хуралдаж, эрх үүргийнхээ хүрээнд шийдвэрүүдийг гарган ажиллаж байна.

**Гүйцэтгэх удирдлага**

Компанийн дүрмийн 12 дугаар зүйлд заасны дагуу компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлэх бөгөөд Гүйцэтгэх захирал нь Компанийн дүрэм, Компанийн засаглал болон бүтэц зохион байгуулалтын баримт, ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэн ажилладаг. Мөн Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, тус тусын харьяалах асуудлуудыг шийдвэрлэх чиг үүрэг бүхий удирдах түвшний албан тушаалтнууд ажилладаг.

Гүйцэтгэх удирдлагын баг нь дараах бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

Гүйцэтгэх захирал Г.Эрдэнэмөнх
Санхүү эрхэлсэн захирал Б.Энхболд
Бизнес хөгжил хариуцсан захирал О.Хонгор
Технологи хариуцсан захирал Д.Жанчив
Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан захирал Ц.Гомбодорж
Ерөнхий нягтлан бодогч Я.Оюунханд
Охин компани болох Дижитал Мерчант Сервисэс ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Гүржав

| | |
|---|---|
| 6. | Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл |
| | Эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд зохицуулагч байгууллагаас гаргасан тогтоол, дүрэм, эрх зүйн актад нийцүүлэн 2023 онд Мэдээллийн аюулгүй байдлын бодлого, холбогдох журам заавруудг, Эрсдэлийн удирдлагын бодлого журмыг шинэчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Эрсдэлийн удирдлагын үр дүнтэй тогтолцоог хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтлан ажиллаж байна.<br><br>□ Үнэт зүйлийг бий болгох, хамгаалах: Компанийн зорилго, зорилтод хүрэх, гүйцэтгэлээ сайжруулах үйл ажиллагааны чухал хэсэг байна.<br><br>□ Шийдвэр гаргалтын салшгүй хэсэг байх: Компанийн удирдлагын зүгээс арга хэмжээг эрэмбэлэн төлөвлөх, сонголт хийхэд дэмжлэг үзүүлдэг байна.<br><br>□ Нөхцөл байдалдаа тохирсон байх: Авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь эрсдэлийн мөн чанар, эх үүсвэрт тохирсон байна.<br><br>□ Ил тод, оролцоог хангасан байх: Компанийн бүх түвшний шийдвэр гаргагчдын оролцоог хангасан мэдээллийн урсгал нээлттэй байна.<br><br>□ Байнга сайжирдаг байх: Эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр дүнтэй байдлыг тогтмол хянаж, тасралтгүй сайжруулдаг байна.<br><br>Манай компанийн үйл ажиллагаанд макро болон микро эдийн засаг, зах зээлийн тогтворгүй байдал, хямрал сөргөөр нөлөөлөх боломжтой. Тухайлбал, дэлхийн төлбөр, тооцооны зах зээлийн борлуулалтын орлого 2020 онд КОВИД-19 цар тахлаас үүдэж 1.9 их наяд төгрөг болж өмнөх оноос 5 хувиар буурсан үзүүлэлттэй байсан нь эдийн засгийн идэвхжил буурсантай холбоотой. Үүнээс үзэхэд эдийн засагт оролцогчдын хэрэглээгээ танах үзэгдэл нь компанийн борлуулалтын орлогод шууд болон шууд бусаар сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байна. Дараах хүчин зүйлс нь Монгол Улсын эдийн засагт өндөр нөлөөлөлтэй байна.<br><br>Үүнд:<br>1. Валютын ханшийн тогтворгүй байдал;<br>2. Үнийн өсөлт, инфляц;<br>3. Ажилгүйдлийн түвшин;<br>4. Түүхий эдийн үнэ ханшийн хэлбэлзэл, нийлүүлэлт;<br>5. Төсөв, мөнгөний бодлого;<br>6. Хил гаалийн хорио, хязгаарлалт.<br><br>Компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөө арвижуулж, үндсэн болон үнэнч хэрэглэгчдээ алдалгүй ажилласнаар дээрх эрсдэлүүдийн нөлөөг бууруулан ажиллаж байна. |
| 7. | Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/ |

Инновэйшн Инвестмент ХХК нь 2023 оны 12 дугаар сард IPO хийсэн ба үнэт цаас гаргах үйл явцад үндсэн андеррайтераар "Өлзий Энд Ко Капитал ҮЦК" ХХК, туслах андеррайтераар "Инвескор Капитал ҮЦК" ХХК нар ажилласан бөгөөд арилжааны системд хувьцааг худалдан авахаар нийт 1,155 хөрөнгө оруулагчийн 1,193 захиалга бүртгэгдэж, арилжаа 100.34%-ийн биелэлттэйгээр амжилттай хаагдсан.

| № | Хувьцаа эзэмшигчийн нэр | Эзэмшиж буй хувьцааны тоо, хувь хэмжээ | |
|---|---|---|---|
| 1 | "Ай Си Ти Групп" ХК | 34,159,320 | 18.48% |
| 2 | Дамдинсүрэн Даваа | 9,108,747 | 4.93% |
| 3 | Чойжоохүү Нарангэрэл | 16,597,400 | 8.98% |
| 4 | "Юнимедиа Солюшнс" ХХК | 15,560,000 | 8.42% |
| 5 | "Айкор Партнерс" ХХК | 14,028,800 | 7.59% |
| 6 | "Рентракс" ХК | 10,373,400 | 5.61% |
| 7 | Батзориг Чулуунсух | 8,900,267 | 4.81% |
| 8 | Шаравхорол Эрдэнэбилэг | 8,370,200 | 4.53% |
| 9 | "Могул" ХХК | 7,482,200 | 4.05% |
| 10 | Масанори Окоши | 3,945,000 | 2.13% |
| 11 | "НОБ" ХХК | 2,593,400 | 1.40% |
| 12 | "Глобал Траст Нетворкс" ХК | 2,593,400 | 1.40% |
| 13 | Шоичиро Ичитани | 2,593,400 | 1.40% |
| 14 | Такахиро Ичики | 2,593,400 | 1.40% |
| 15 | Мөнхчулуун Мөнхбаяр | 1,141,066 | 0.62% |
| 16 | КKTT ХХК | 7,871,542 | 4.26% |
| 17 | Олон нийт | 36,977,618 | 20.00% |
| | **Нийт дүн** | **184,889,160** | **100.00%** |

8. Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл

Инновэйшн Инвестмент ХХК нь СЗХ-ны 2023/11/08-ны өдрийн 551 тоот тогтоолоор IPO хийх зөвшөөрлөө авсан бөгөөд 2023/12/04-ний өдрөөс 2023/12/08-ны хооронд Монголын хөрөнгийн бирж дээр анхдагч зах зээлийн захиалга авч 8.3 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн.
Татан төвлөрүүлсэн хөрөнгийг дараах байдлаар зарцуулахаар төлөвлөсөн. Үүнд:

| № | Хөрөнгө оруулалтын зориулалт | Эзлэх хувь |
|---|---|---|
| 1 | Бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үндсэн үйл ажиллагааны тэлэлт | 22.5% |
| 2 | Дунд хугацааны төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалт хийх үйлажиллагаа | 30.0% |
| 3 | Техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийгсайжруулах үйл ажиллагаа | 15.0% |
| 4 | "КKTT" ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг энгийн хувьцааны төлбөр | 25.0% |
| 5 | Олон улсын зах зээлд үйл ажиллагаа өргөжүүлэхтэй холбогдуулан хүний нөөц, менежментийн ур чадварыг сайжруулах | 7.5% |

2023 онд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 25% буюу "КKTT" ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг энгийн хувьцааны төлбөр болох 2,080,003,050 төгрөгийг зориулалтын дагуу КKTT ХХК руу шилжүүлсэн. Тайлант жилд өөр ямар нэгэн зарцуулалт хийгдээгүй.

9. Ногдол ашгийн мэдээлэл

| | |
|---|---|
| | Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 02/02 тоот тогтоолоор хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн. Үүнд: Инновэйшн Инвестмент ХК-ийн 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 21.63 /хорин нэгэн төгрөг жаран гурван мөнгө/ төгрөгөөр тогтоож, Компанийн 2023 оны цэвэр ашгийн 70.2 /дал аравны хоёр/ хувь буюу 4,000,000,000.00 /дөрвөн тэрбум/ төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлэсэн. СЗХ-ны 2024 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 3/712 тоот тогтоолын дагуу тус ногдол ашгийг 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулж хуваарилахаар төлөвлөж байна. |
| 10. | Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл |

**Байгаль орчин, нийгэм, засаглалын тогтвортой хөгжлийн бодлого**

"Инновэйшн Инвестмент" ХХК нь бүх шатны үйл ажиллагаандаа Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Тогтвортой Хөгжлийн зорилтуудыг 2020 оноос хойш хэрэгжүүлэн ажиллаж байна. Байгууллагын тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд "Инновэйшн Инвестмент" ХХК нь өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан байгаль орчин, нийгэм эдийн засагт эерэг нөлөөлөл бий болгох, дотоод үйл ажиллагаагаа байгаль, нийгэмд ээлтэй болгохоор зорин ажиллаж байна. "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн байгаль орчин, нийгэм, засаглалын тогтвортой хөгжлийн бодлогын чиглэл нь тогтвортой бизнесийн үйл ажиллагааг явуулах, нийгэм, байгаль орчны асуудлуудад анхаарал хандуулах, тогтвортой, сэтгэл ханамжтай ажлын байрыг бий болгох юм.



*Зураг. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилтууд - 2030*
*Эх сурвалж: НҮБ*

**Байгаль, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн тухай**



"Инновэйшн Инвестмент" ХХК-аас үзүүлдэг Qpay үйлчилгээ нь цахим төлбөрийн хэрэглээг хялбар болгож, QR төлбөр тооцоог хүн бүрд нээлттэй болгон ойртуулсан билээ. Энэхүү үйлчилгээний нөлөөллөөр Хэрэглэгчид банкны урт дараалалд зогсолгүй цахим QR гүйлгээгээр төлбөрөө гүйцэтгэх болсон. Хэрэглэгчийн тоо нэмэгдэх хэрээр цаг хугацаа, шаардлагагүй зардал болон хог хаягдал буурж, бүх талуудын сэтгэл ханамж өсөж байна.

Банкны 1 гүйлгээний ард 1 ширхэг А4 цаас ашиглагддаг гэж үзвэл Qpay үйлчилгээ нь 2023 оны турш зөвхөн төрийн үйлчилгээний хувьд 2,268,458 ширхэг цаас хэмнэснээр 272 мод, 837 тонн ус, 39м3 нүүрс хүчлийн хийн ялгаруулалтыг тус тус хэмнэсэн байна.

"Инновэйшн Инвестмент" ХХК нь Qpay үйлчилгээг Монгол Улсын зах зээлд нэвтрүүлснээс хойш доорх хэмнэлтүүдийг бий болгож цахим төлбөр тооцооны шинэ соёлыг нэвтрүүлжээ. Үүнд:

| 2023 | Ширхэг цаас | Мод | Ус /тонн/ | CO2 ялгаруулалт /м3/ |
|---|---|---|---|---|
| Төрийн үйлчилгээнд | 2,268,458 | 272 | 837 | 39 |
| Нийт QPay үйлчилгээнд | 121,390,614 | 14,567 | 44,668 | 2,097 |

**Нийгэм, эдийн засаг дахь нөлөөллийн тухай**



"Инновэйшн Инвестмент" ХХК нь нийгэм, эдийн засгийн тогтвортой байдалд дараах хувь нэмрийг оруулжээ.

• Амьдралын хэв маягийг хялбар, аюулгүй болгох: Qpay үйлчилгээ нь олон улсын төлбөрийн системүүдтэй холболт хийгдсэнээр гадаад улсад суралцагч оюутан залуус болон аялагч, бизнес эрхлэгч Монгол Улсын иргэд бэлэн мөнгөөр гүйлгээ хийх шаардлагагүй болж бэлэн мөнгөтэй болон мөнгөн гуйвуулгатай холбоотой гарч буй гэмт хэргийн тоог бууруулах боломжийг бүрдүүлсэн.

• Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, цахимжуулах хөтөлбөрийг дэмжих: Төрөөс үзүүлж буй бүхий л үйлчилгээний төлбөрийг үйлчилгээг ашиглан шимтгэлгүйгээр, хурдан, хялбараар гүйцэтгэх боломжтой болсон нь иргэд болон төрийн албаны цагийг хэмнэж, ачааллыг бууруулсан шийдэл болсон.

• Жижиг, дунд, бичил бизнес эрхлэгчдийг дэмжих: Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор стикер QR кодыг ашгийн төлөө худалдалгүй, үнэгүй хэвлэн тарааж өгсөн. Мөн Мерчантууд нь бүртгэлийн хураамжгүйгээр Qpay Мерчант аппликэйшн эсвэл вэб хуудаст хандан бүртгүүлэн орлогын мэдээлэл, гүйлгээний түүхээ үзэх боломжтой байна.

• Нийгмийн хариуцлагын хүрээнд УИХ-ын сонгуулийн нэр дэвшигчийн хандивын эх үүсвэрийг нээлттэй тодорхойлох боломжтой тусгай QR гүйлгээг нэвтрүүлсэн.

"Инновэйшн Инвестмент" ХХК нь байгууллагын засаглалын тогтвортой байдалд дараах үзүүлэлтүүдийг баримталж байна.

• "Инновэйшн Инвестмент" ХХК нь группийн хэмжээнд ажилтнууд жендерийн эрх тэгш харьцаатай байж бие биеийнхээ эрх, үүрэг, харилцааг хүндлэн ажиллах соёлтой байхыг дэмжлэг. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үед хүйсийн харьцаа 50:50 байна.

• "Инновэйшн Инвестмент" ХХК нь засаглалын хүрээнд удирдлагын бүтэц, зохион байгуулалт, бодлого, тогтолцоонуудыг оновчтой, зөв зохистой, болгон бүрдүүлж хөгжүүлэхэд анхаарч ажиллаж байгаа бөгөөд нэн тэргүүнд үнэн, зөв мэдээллээр удирдлагыг цаг алдалгүй хангаж, шийдвэр гаргалтыг бодитой, оновчтой, шуурхай, зөв зохистой болгох механизмыг бүрдүүлж, ил тод, нээлттэй, өндөр хариуцлагатай гүйцэтгэлийн удирдлага, хяналтын тогтолцоог бий болгон бэхжүүлэх чиглэлээр сайжруулалт хийн ажиллаж байна.

• "Инновэйшн Инвестмент" ХХК нь цалин, урамшууллын тогтвортой байдлыг хангахын тулд ажилтны гүйцэтгэлийг үнэлэх, урамшуулал олгох журмыг бэлтгэн нэвтрүүлэхээр ажиллаж байна.

• Мэдээллийн аюулгүй байдлын чанарыг сайжруулж дотоод үйл ажиллагаандаа ISO:27001 стандартыг нэвтрүүлсэн бөгөөд харилцагчийн мэдээллийг хамгаалах найдвартай байдлыг хангах зорилгоор олон улсын төлбөр тооцооны хэрэгсэлд тавигддаг PCI:DSS стандартыг нэвтрүүлээд байна.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Г.Эрдэнэмөнх

Албан тушаал: "Инновэйшн Инвестмент" ХК-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг: .....................................

*(Тамга/тэмдэг)*

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Б.Энхболд

Албан тушаал: Санхүү эрхэлсэн захирал

Гарын үсэг: .....................................

*(Тамга/тэмдэг)*